

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.08.23, БААСАН ~ №142 (1194)

~ МОНГОЛ ХҮН БҮР БАЯЖИГТУН ~

ҮНЭ: 1000Т

Эдийн засгийн “эрх чөлөө” хүссэн хотын парламентын санал

Хот, тосгоны эрх зүйн зохицуулалт үүргээ гүйцэтгэж чадахгүй байна. >2

Хөлбөмбөгийн шигшээгээ дэмжих өдөр

Хэсэг тус бүрээс хоёр баг дараагийн шатанд шалгаран өрсөлдөх юм. >6

“Илон Маскийн цахилгаан машин стиль болохоос шийдэл биш”

Сингапурын галт тэрэг, автобус нь арал улсын нутаг дэвсгэрийг бараг бүхэлд нь хамардаг. >8

FULL ENGLISH PAGE INSIDE

ZGM DAILY >5

ОНЦЛОХ

УЛС ТӨР
Мал хамгаалах санг татан буулгаснаар зарим урамшууллыг олгох нэгж тодорхойгүй болжээ.
Ерөнхийлөгч “Англи хэлтэй залуус” хөтөлбөрийн хаалтын үйл ажиллагаанд оролцов.
Өргөдлийн байнгын хорооноос нээлттэй хаалганы өдөр арга хэмжээг зохион байгууллаа.
УИХ-ын гишүүнийг 99 болгож, таван жилээр сонгодог байхыг МАН-ын бүлэг дэмжлээ

ЭДИЙН ЗАСАГ
“Лэнд МН ББСБ” Өмнөд Солонгосын зах зээлд хадгаламжийн бичиг гаргахаар төлөвлөж байна.
Иргэдэд олгосон зээлийн 37 хувийг ипотека эзлэв.
Татварын нийт орлого 22.7 хувиар өслөө.
Улсын хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин 60.8 хувь байна.
ТОП 20 индекс 0.01 хувиар өсөж, зах зээлийн үнэлгээ 2.5 их наяд төгрөгт хүрлээ.



НИЙГЭМ
Цэцэрлэгийн цахим бүртгэлийн хариу өнөөдөр 10.00 цагаас эцэг эхчүүдэд мессежээр ирнэ.
НЗДТГ гэр хорооллыг дахин төлөвлөхөд Барилгын үндэсний Ассоциацийн хамтарна.
Шөнийн цагаар охид эмэгтэйчүүдийг дээрэмддэг дөрвөн бүлэг 15 этгээдийг ЭЦГ баривчлав.
Сайжруулсан тулш борлуулахаар гэрээ байгуулсан ердөө 240 иргэн байна.

ДЭЛХИЙ
Америкийн еврейчүүд “юм ойлгодоггүй, эс бөгөөс дуулгаваргүй хүмүүс” хэмээн Трамп үзлээ.
Уян хатан орчинд ажиллах сонирхол ихэссэн Японд 3.5 сая хүн фриланс хөдөлмөр эрхэлж байна.
АНУ ирэх хоёр жилийн дотор дуунаас хурдтай зэвсэг бүтээх гэж байгааг Пентагон мэдэгдэв.
Сан-Францискогийн нисэх буудал хуванцар лонхонд савласан усны худалдааг хориглолоо.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
 2019.08.23

24° | 11°

БОРООТ

8 658 000 029 112 0 1194

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

НААДАМ ДУУСААГҮЙ БАЙХАД ЦАС, ХАДЛАН ЯАХ ВЭ



Албан ёсны наадмын дараах албан бус бэсрэг наадмууд бараг хоёр сарын турш үргэлжилсэн хэрнээ дуусах яагаа ч үгүй байна. Аймгийн харцага, аймгийн начин цол хүртсэн бөхчүүд хүртэл бэсрэг наадам хийж, бөх барилдуулж, морь уралдуулж, сур харваад байгааг юу гэж ойлгох вэ. >3

ЗГМ: ЗОЧИН Үйлчлүүлэгчдийн маань 90 хувь нь Instagram-аар “дамжин” ирдэг

Б.Бадамцэцэг
 ЗГМ

Өдөр бүр маш их хэмжээний контент Facebook, Youtube, Instagram, Twitter зэрэг нийгмийн сүлжээнд нийлэгдэж байна. Зөвхөн Instagram-д л гэхэд секунд тутамд 2100 пост шинээр нийлэгддэг. Энэ бол бизнес эрхлэгчдийн хувьд алдаж болохгүй том боломж. Харин энэ боломжийг хамгийн сайн ашиглаж буй хувцас загварын компани бол залуусын 93//KiD-ULT брэнд юм. Хувцас загвар бол тухайн нийгмийн амьдралын хэв маяг, залуусын үзэл бодлын тусгал болдог. Бизнесийн шинэ хэв маягийг амжилттай хэрэгжүүлж, трэнд болоод буй 93//KiDULT брэндийн урлангаар зочилж, үүсгэн байгуулагчдын нэг, ахлах загвар зохион бүтээгч М.Нямсүрэнтэй ярилцлаа.

МИНИМАЛИСТ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ БА ХУВЦАС ЗАГВАР
 Хотын төвд байрлалтай жижигхэн дэлгүүрийн хаалгыг татахад ахлах загвар зохион бүтээгч М.Нямсүрэн биднийг угтав.

> 4

ЭДИЙН ЗАСАГ Трамп Гринландыг худалдан авч чадах уу? Үгүй, гэхдээ...

Мортен Баттлер
 АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Данийн харьяанд байдаг өөртөө засах эрхтэй, дэлхийн хамгийн том арал гэгддэг Гринландыг худалдан авах тухай үг цухуйлгасан нь энэ долоо хоногт нэлээд шуугиан тарилла. Тэр үнэхээр хүссэн эсэх нь тодорхойгүй ч нөгөө тал нь “Үгүй” гэдгийг хатуухан мэдэгдэв. Гэхдээ ийм наймаа боломжтой юу гэдэг асуудал улстөрчид, судлаачдын дунд өрнөж эхэллээ.

1. Трамп яагаад Гринландыг сонирхох болов?
 Ул хөдлөхийн барон байсан Трамп геополитикийг тэр өнцгөөс

хардаг бололтой. Жишээ нь, 2018 онд Ким Жон Унтай уулзах үедээ Хойд Солонгосын эрэг хавьд зочид буудал, орон сууц барих тухай ярьж байв. Мөн Трамп гэгддэг Гринландын том арлыг худалдан авах санал гаргасан Ерөнхийлөгч гэж түүхэнд бичигдэхийг мэдэж байгаа нь лавтай.

2. Арал АНУ-д яагаад чухал вэ?
 Гринланд яагаад АНУ-д хэрэгтэй вэ гэвэл Саудын Араб, Мексикийн адил арвин их байгалийн нөөцтэй агаад Арктикийн дулаарч буй бүсэд стратегийн чухал байрлалтай.

> 8

ЗГМ: ИНФОГРАФИК



ЭДИЙН ЗАСАГ ДНБ зоосны зөвхөн нэг талыг харуулдаг

Г.Байгал
 @baigalZGM

Эдийн засгийг зөвхөн ДНБ-ээр хэмжих нь хоцрогдож байна. XX зууны турш дэлхийн эдийн засгийн халууны шил байсан энэ үзүүлэлтийн сул тал, дутагдал илчлэгдсээр. Дэлхийн хөгжил нүд ирмэхийн зуур өөрчлөгдөж, дижитал эдийн засаг хүчирхэгжихийн хэрээр ДНБ-ээр эдийн засгаа хэмжихийг шүүмжлэгчдийн дуу хоолой чангарч, шинэ арга хэмжүүр нэхэж эхэллээ.

Дэлхийн шилдэг эдийн засагчдаас бүрдсэн санхүү, судалгааны байгууллагууд ДНБ-ий сул талыг илчилж эхэлсэн. Зөвхөн ДНБ-ий өөрчлөлтөөр эдийн засгийн нарийн зүйлийг харах боломжгүй хэмээн Орлого, баялгийн судалгааны олон улсын холбооноос үзсэн бол энэ хэмжүүр дижитал эдийн засагтай уялдуулахгүй байгааг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага шүүмжлэв.

ДНБ нь зоосны зөвхөн нэг талыг харуулдаг. Энгийнээр тайлбарлавал, үйлдвэрүүд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон хүн ажиллаж, иргэд халаасандаа илүү мөнгөтэй болсноор ДНБ-ийг өсгөдөг. Өөрөөр хэлбэл, улсын эдийн засгийн өсөлтийг мөнгөн үнэ цэнээр илэрхийлдэг гэсэн үг. Гэтэл энэ хэрээр иргэдийн амьдрал сайжирдаг уу.

> 7

АЛТ 1498.33 0.29%	ЗЭС 5732.00 0.37%	10-ЧИНГИС БОНД 98.700 0.13%	ХУРАЛДАЙ БОНД 110.70 0.12%	ГЭРЭГЭ БОНД 99.330 0.12%	АМ.ДОЛЛАР 2673.17	ЮАНЬ 378.65	РУБЛЬ 40.38
--------------------------------	--------------------------------	--	---	---------------------------------------	-----------------------------	-----------------------	-----------------------

Улс төр

Эдийн засгийн “эрх чөлөө” хүссэн хотын парламентын санал

Хот, тосгоны эрх зүйн зохицуулалт

үүргээ гүйцэтгэж чадахгүй байна

Б.Энхжаргал
@enkhjrglZGM

Олон улсад хүний материаллаг болон оюуны хэрэгцээг хангах, материаллаг баялаг үйлдвэрлэх, улс төр, эдийн засаг, оюун санааны төв гэж үздэг тодорхойлолтод Улаанбаатар болон Дархан, Эрдэнэт хот тэнцэх үү.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг УИХ-аар ид хэлэлцэж буй өнөө үед дээрх асуултад нэг мөр хариулт олох хэрэгтэйг олон нийт хэлж байна.

Монгол Улсын Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу тэдгээрийн захирагчдад эдлүүлэх эрх, үүрэг зарим талаар гүйцэт хэрэгжиж, төлөвшиж чадаагүй, заримдаа засаг захиргааны нэгжийн эрх үүрэгтэй хутгалдсан гэж судлаачид үзэж байна. Засгийн газраас төсөв санхүүгийн хувьд хэт хараат Улаанбаатар хот бие даахыг эрэлхийлж, хуучин улсын зэрэглэлтэй байсан Дархан, Эрдэнэтийн иргэд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болгох санал хүсэлтийг тасралтгүй илэрхийлсээр ирсэн. Шинэ тогтолцоогоо оновчтой зохион байгуулж чадаагүйгээс хотууд хуучнаа санагалзаж, харин



Олон улсад хотыг улс төр, эдийн засаг, оюун санааны төв байх ёстой гэж үздэг.

С.Батсайхан / ЗГМ ©

нийслэл Улаанбаатар “эрх чөлөө” хүсэж буйг буруутгах аргагүй. Угаасаа олон улсад хот нь төсвөө бие даан бүрдүүлдэг, дэд бүтэц болон барилга байгууламж, хотын хэлбэр дүрсээрээ өөрийгөө тодорхойлдог, төсөв хөрөнгөө захиран зарцуулдаг, бусдаас буюу Засгийн газар, засаг захиргааны нэгжээс хараат бусаар бие даан хөгжих чадвартай байх ёстой гэж үздэг аж.

Тэгвэл НИТХ-аас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд оруулах саналаа хүргүүлжээ. Тэгэхдээ хуулийн төслийн 57.2 дугаар заалтад ихээхэн ач холбогдол өгсөн байна.

1992 онд баталсан шинэ Үндсэн хуулийн тус заалтад “Монгол Улсын Засаг захиргаа,

нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэсэн ганцхан өгүүлбэр л бий. Харин өнгөрсөн 27 жилийн хугацаанд тус заалтын үзэл санаагаар амьдарч ирсэн нийслэл хот хэрхэн хөгжив.

“Энэ хугацаанд та бидний ажил, амьдралд хангалттай ашигтай байж чадсан уу гэвэл дундуурхан гэж хэлэх байх. Энэ заалт тухайн цаг үедээ л үүргээ гүйцэтгэсэн байж магадгүй. Тиймээс цаашид тухайн заалтаар бүгдийг зохицуулах боломжгүй болсоор байгаа юм. Захиргааны болон санхүүгийн эрх мэдлийг нээх үзэл санааг Үндсэн хуульд тусгуулах нэн шаардлагатай байна” гэж НИТХ-ын дарга Р.Дагва ярих.

Хоттой холбогдолтой Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчлэлтэй холбогдуулан хийнэ. Тиймээс хүсээд байгаа эрх, статусаа Үндсэн хуулийн үзэл санаанд суулгах ёстой гэж “хотын парламент”-ын гишүүд үзэж байна.

Мөн хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт буй нутгийн удирдлагын тогтолцоо, нутгийн удирдлагын байгууллагын эрх зүйн үндсийг өөрчлөх шаардлагагүй гэж тус саналд тусгажээ. Төсөлд тусгаснаар

Монгол Улсын нутгийн өөрөө удирдлагын үндсэн нэгж нь сум, дүүргийн ИТХ байх. Мөн аймаг, нийслэлийн ИТХ-ыг сум, дүүргийн хурлаас бүрдүүлэхээр оруулсан.

Нийслэлийн ИТХ дүүрэг дээр очоод, сонгуулийн тодорхой тойргоос сонгогдож байна. Гэтэл дүүргийн ИТХ мөн л иргэдээсээ сонгогддог. Өөрөөр хэлбэл, давхардал үүсч байгаа учраас НИТХ-ыг дүүргүүдийн хурлаас бүрдүүлдэг байхаар төсөл санаачлагчид тайлбарласан.

Харин үүнийг яг аль хурал нь нутгийн удирдлагын үндсэн байгууллага байх, чадамжаараа аль нь илүү хүчтэй гэдгийг бодолцоо эстой гэж НИТХ-ын төлөөлөгчид саналдаа тусгасан байна. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» **УЛААНБААТАР**
Нийслэлийн Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагчийн хэлснээр өнөөдрийн байдлаар сайжруулсан түлшийг иргэдэд хүргэх 240 борлуулагчтай гэрээ байгуулжээ. Мөн Амгалан, Дөлгөөн нуурын баазуудад 20 мянга орчим тонн түлш нөөцөлсөн байна. Хэрэглэгчид сайжруулсан шахмал түлшийг худалдан авахдаа “Сайн” гэдэг смарт карт ашиглах аж.

» **ТОО**

158.5

Тэрбум төгрөг. “Мал хамгаалах сан”-г татан буулгаснаар хонь, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгох чиг үүрэг бүхий нэгжгүй болжээ. Засгийн газрын шийдвэрийн дагуу 2017 он хүртэл нийт 593.7 мянган малчин, мал бүхий этгээдийн тушаасан 112.3 мянган тонн хонь, тэмээний ноосонд 158.5 тэрбум төгрөгийн урамшууллыг Монголбанкнаар дамжуулан олгосон байна.

» **БҮРТГЭЛ**

Төрийн өмчийн цэцэрлэгийн цахим бүртгэл өчигдөр 23.59 цаг хүртэл үргэлжлээ, хаасан. Цахим элсэлтийн үйл ажиллагаа өнөөдөр 09.00 цагаас нийслэлийн хэмжээнд нэгэн зэрэг явагдах юм. Өнөөдөр 10.00 цагаас эхлэн эцэг, эхчүүдийн гар утсанд хариу зурвас илгээгдэх аж.

НАМУУД

Ардчилсан залуусын шинэ давлагаа

Ардчилсан нам 2019

оныг залуусын хөгжлийг дэмжих жил болгон зарласан

Б.Сэлэнгэ
ЗГМ

“Хонины бэлчээрт модон шилбүүр барьж явнаас тайзан дээр микрофон бариад үг хэлнэ гэж төсөөлсөнгүй явлаа. Энэ бол залуус бидэнд олдсон тэгш боломж”.....хэмээн Увс аймгийн Баруунтүрүүн сумын малчин бүсгүй ярьж байна. Эдүгээ 20 гаруй настай малчин бүсгүй ардчиллын алган дээр өсч, өндийсөн “Ардчиллын бүтээгдэхүүн” хэмээн өөрийгөө тодорхойлсон юм.

Ардчилсан нам энэ оныг “Залуусын хөгжлийг дэмжих жил” болгон зарласан. Энэ хүрээнд “Шинэ давлагаа” бүсийн чуулгануудыг амжилттай зохион байгуулж байна. Одоогоор зүүн, баруун, хангайн бүсийн залуус “Шинэ давлагаа”-нд нэгдсэн бол тун удахгүй Төвийн бүсийн залуус чуулж, ирэх сард говь нутгийн хөгжлийн түүхээ болсон залуус “Шинэ давлагаа”-нд нэгдэхээр эхэж буй.

Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын нутаг Улаагчны хар нуурын эрэгт гурван өдрийн турш зохион байгуулагдсан “Шинэ давлагаа” баруун бүсийн чуулганд оролцогчид үнэхээр ч энэ цагийн эзэд болсон 18-35 насныхан байв. Энэ удаагийн чуулганд Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий аймгаас гадна нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан дүүргийн залуусын төлөөлөл бүхий 800 гаруй хүн оролцож, Ардчиллын үнэт зүйл, Ардчилсан намын Үзэл баримтлал, орон нутгийн



Монголын залуус өөр зүйлийг хүсч байна. Аргалаад өнгөрөх бус, зохицоод явах биш болно гэдэг зүйлд итгэж, үнэмших нь чухал.

хөгжил, улс төр дэх залуусын оролцооны талаар хэлэлцэж, сургалтад хамрагдлаа. Үүний зэрэгцээ Улаагчны хар нуурын эрэгт цугласан залуус гар бөмбөг, орс таталт зэрэг спортын наадамд хурд хүч, авхаалж самбаагаа сорьж, урлагийн наадамд авьяас чадвараараа өрсөлдөж, уйдаах завгүй гурван өдрийг өнгөрүүлсэн юм. Баруун бүсийн залуусын чуулга уулзалт нээлтийн арга хэмжээнээсээ эхлээд шинэлэг, өнгөлөг байв. Энэ үеэр нутаг, нутгийн хоолны соёл, идээ ундааны онцлогийг харуулсан “FOOD FESTIVAL”, “Ардчилсан оюутны холбоо”-ны “Хувь хүний эрх чөлөө”, “Эдийн засгийн эрх чөлөө” сэдвээр зохион байгуулсан илтгэлийн тэмцээн, галын наадам, сургалтууд гээд онцлох зүйлс олон байв. “FOOD FESTIVAL”-ийн үеэр Өлгийчүүд казаар дайж, Завханчууд хар нуурынхаа загасаар зоог барьж, олон ястны өлгий нутаг Ховдчууд шинэ ургацынхаа ногооны дээж болох амтаг тарвас, жимс, Алтайчууд нутгийн брэнд болсон амтаг

дарс, ааруул, хурууд, чацарганаар оролцогчдыг дайласан юм. Баруун бүсийн чуулганд 800 гаруй залуус авьяас чадвар, авхаалж самбаагаа сорьсноос Говь-Алтай аймаг шилдгээр шалгарч, цомын эзэн болов. Удаах байрт Ховд, гуравдугаар байранд Увс аймаг тус тус шалгарсан юм. “Ардчилсан оюутны холбоо”-ноос зохион байгуулсан илтгэлийн тэмцээнд Ховд аймгийн илтгэгч тэргүүлж, Баянгол дүүрэг удаах байрыг эзэлж, Увс аймгийн илтгэгчид гурав, дөрөвдүгээр байрт шалгарлаа.

“УРАМ ЗОРИГТОЙ ИРЭЭДҮЙ, ҮНЭТ ЗҮЙЛТЭЙ ЗАЛУУС, ҮЗЭЛ БАРИМТЛАЛТАЙ АРДЧИЛАЛ”

Зүүн бүсийн залуусын чуулга уулзалт Дорнод аймгийн Баянтүмэн суманд зохиогдсон бол Хангайн бүсийн залуус Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутагт чуулсан юм. Хангайн бүсийн чуулга уулзалтад Булган, Орхон,

Дархан-Уул, Хөвсгөл, Сэлэнгэ, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн 1000 орчим залуус оролцсон. Хангайн бүсийн чуулга уулзалтад Булган аймгийн залуус багийн дүнгээрээ тэргүүн байрт орж, шилжин явах цомын эзэн болсон бол Орхон аймаг хоёрдугаар байрт, нийслэлийн Хан-Уул дүүрэг гуравдугаар байрт тус тус шалгарлаа. Ардчилсан намын УБХ-ны гишүүд “Шинэ давлагаа” чуулганы үеэр Ардчилсан намын Үзэл баримтлалыг таниулах сургалтыг сонирхолтой хэлбэрээр зохион байгуулж байгаа нь оролцогчдод өндөр сэтгэгдэл үлдээсэн тухай залуус хэлж байна. Түүнчлэн “Хоггүй чуулгаая” уриалгыг дэвшүүлж, дараа, дараагийн чуулганд оролцогчдыг байгаль орчинд ээлтэйгээр чуулахыг уриалсан нь Хангайн бүсийн чуулга уулзалтын онцлог байв. Оролцогчдыг таван хэсэгт хувааж “Хувь хүний эрх чөлөө”, “Эдийн засгийн эрх чөлөө”, “Улс төрийн эрх чөлөө”, “Шударга ёсны эрх чөлөө”, “Үндэсний эрх чөлөө” гэсэн үндсэн сэдвийн хүрээнд

өртөөчлөн сургалт зохион байгуулж, залуусын идэвхи, оролцоо өндөр, асар дүүрэн хүнтэй өрнөсөн юм.

Сургалтын багийн ахлагчаар Ардчилсан намын УБХ-ны гишүүн Б.Ган-Очир ажиллаж байгаа бөгөөд тэрбээр “Мөнгө, албан тушаал нэгдүгээрт бичигддэг цаг өнгөрч байна. Цаашид улс төрийн намд Үзэл баримтлал тэргүүнд бичигдэх болно. Энэ бол шинэ давлагаа юм. Өнгөрсөн 30 жилийн турш засаг, төрөөс эхлээд нийгмийн ухамсар бүхэлдээ мөнгө, албан тушаал гэсэн хоёрхон зүйл дээр төвлөрч, харанхуй руу унасан. Тэгвэл цаашид Монгол Улс хаашаа чиглэх юм бэ. Мөнгө, албан тушаалыг чухалд тооцооор, харанхуй нүхэндээ байсаар байх уу. Ардчилсан залуус үүнийг хүсэхгүй байна. Монголын залуус өөр зүйлийг хүсч байна. Аргалаад өнгөрөх бус, зохицоод явах биш болно гэдэг зүйлд итгэж, үнэмших нь чухал. Нам гэдэг мөнгөтэй болох арга хэрэгсэл биш, албан тушаалд хүрэх гүүр бус. Үзэл

баримтлалаараа нэгдэж, бусдын төлөө ажилладаг хүмүүсийн нэгдэл байх ёстой. Энэ соёлын давлагаа бол шинэ давлагаа юм” гэв.

Чуулганы үеэр “Ардчилсан залуучуудын холбоо”-ны ерөнхийлөгч С.Эрдэнэболд “Ардчиллын анхдагч болсон залуус өвлийн тэсгим хүйтнийг сөрж, ардчиллын төлөөх тэмцлийг анх эхлүүлж байлаа. Залуус бол улс орны хөгжлийг түүчээлэгч, шинийг эрэлхийлэгчид байдаг. Ирээдүй гэрэлтүүлэх сайн сайхан бодол бүх хүнд нэгэн зэрэг төрдөггүй. Гэгээн цагаанаар ирээдүйгээ төсөөлдөг урам зориг, итгэл төгс залуусын толгойд эхэлж төрдөг. Иймээс бид орон нутагтаа манлайлагч залууст шинэчлэгдсэн Ардчилсан намын Үзэл баримтлалыг ойлгуулан, таниулахыг хүссэн юм” гэлээ.

Залуус улс төрийн намыг албан тушаалд хүрэх гүүр, мөнгөтэй болох гаргалгаа бус, “Цүнх баригч”, “Бөгс долоогч”, хэн нэг даргыг аялдан дагалдагч гэдэг нийгмийн ухамсарт тогтсон нэр, томъёолол, үг хэллэг, ойлголтоос татгалзаж, нийгэмдээ оролцоотой амьдрахыг хүсч байгаагаа чуулга уулзалтын үеэр илэрхийлж байлаа. “Нийгэмдээ оролцоотой амьдрахыг улс төрд орох гэж хэлнэ. Бид сум, орон нутгаа хөгжүүлээр байна, нийгэмдээ оролцоотой амьдрахыг хүсч байна. Үүний тулд улс төрийн намыг дэмжиж, гишүүнээр нь элдсэг. Гэтэл залуус улс төрийн намд элсэхээр нийгэм “Цүнх баригч”, “Бөгс долоогч” хэмээн тодорхойлдог. Бид нийгэмд тогтсон энэ харанхуй ойлголтыг өөрчлөхийг хүсч байна” хэмээн 20 настнууд хэлж байна. “Урам зоригтой ирээдүй, үнэт зүйлтэй залуус, Үзэл баримтлалтай Ардчилал” уриан дор Ардчилсан залуус шинээр давлагаалж байна. Эерэг хандлагыг түгээж, байгаль орчиндоо ээлтэй, хоггүй чуулж, Үзэл баримтлалынхаа туган дор нэгдсэн залуус шинээр давлагаалж байна.

Нийтлэлчийн булан



Жил бүр 120 орчим бөх шинээр аймаг, улсын цол хүртдэг гэх ерөнхий багцаа бий. Энэ олон цолтнуудын ихэнх нь мялаалга наадмаа хийдэг болсон гэж тооцвол найр наадмын хөл есдүгээр сар гарсан ч тасрахгүй бололтой.

дундаж тоонд дөхөж очихоор байна. Харин энэ олон цолтнуудын ихэнх нь мялаалга наадмаа хийдэг болсон гэж тооцвол найр наадмын хөл есдүгээр сар гарсан ч тасрахгүй бололтой.

Бөхчүүд цолны мялаалга наадмаа хийнэ үү, болино уу бидэнд ямар хамаатай юм гэж зарим нь бодож магадгүй. Тийм биш юм аа. Учир нь шинэ цолтон бүр мялаалга наадмаа тухайн аймаг, сумын захиргаатай хамтран зохион байгуулдаг. Сумын Засаг даргын тамгын газрын ажилтнууд энэ хэдэн өдөр бүхэлдээ наадмын зохион байгуулалтад дайчлагдана. Мөн наадам зохион байгуулахад орон нутгийн төсвөөс чамгүй мөнгө зарцуулчихна. Бусад сумынхан шинэ цолтны наадмаа сайхан хийгээд байхад бид юунаас нь дутдаг юм гэх монгол зан үүнд нэрмээс болно.

Зөвхөн бөхийн тухайд ярихад ийм байна. Үүнээс гадна харваачид, шинэ цолны болзол хангасан уяачдын наадам гээд цааш үргэлжилнэ. Тийм харваачийн мэргэн цолны мялаалга наадам, ийм уяачийн алдрыг тэмдэглэх наадам гээд зөндөө л сонссон байх. Тэр ч байтугай хүүхдийн сэвлэг үргээх баярт зориулан бэсрэг наадам хийж, морь уралдуулах үеэр нэг нөхөр хоёр настай хүүхдээ морин дээр баглаж уяад уралдуулсан гэх дуулиан өнгөрсөн жил гарч байлаа. Аав нь тухайн үед торгуулаад өнгөрсөн санагдана. Гэхдээ даахины найранд зориулж бэсрэг наадам хийнэ гэдэг арай л дэндүү аархал уу.

Жижиг хэмжээний ганц наадам зохион байгуулахад хамгийн багадаа 20 сая төгрөгийн зардал гардаг гэх багцаа бий. Бөх, морь, сур харвааны бай шагнал, дуучдын үнэ хөлс, ирсэн зочдыг дайлж цайлах мөнгө болон зохион байгуулалтын бусад зардал багтаад энэ. Арай том, хөлтэйхөн наадам хийнэ гэхэд энэ зардал улам өсөх нь тодорхой. Өнгөрсөн зун манай нэгэн алдартай аваргад зориулсан наадам баруун аймгийн төрсөн суманд нь болж өнгөрлөө. Хамгийн гол нь эл наадмын бүх

зардал тухайн сумын төсөрхөн төсвийг шавхаад зогсохгүй сумын албан хаагчдын цалингаас татаас авч байж нэг юм зохицуулсан тухай чих дэлслээ.

Ингэж наадмаалад цэнгэл авдаг гэвэл нэн харамсалтай биш гэж үү. Гэтэл ийм хэмжээний зардалтай наадам 21 аймаг, 330 суманд жил бүр хэд хэдээрээ болж байна гээд төсөөл дөө. Ямар их үргүй зардал урсаж байгаа бол. Наадам хийж буй энэ мөнгөөр сумандаа ганц боловсон жорлон барьчих сэтгэл даанч алга даа.

Наадмын маргаааш намар гэж монголчууд ярьдаг. Наадамлаж дууссан бол намар, өвлийн бэлтгэлээ эртхэн базаахыг сануулсан үг. Хотынхон ч яахав, дулаан хувцсаа зэхсэн байхад өвлийн бэлтгэл ерөнхийдөө болоод явчихна. Харин хөдөөгийн малчдын хувьд хадлан тэжээлээ бэлдэхээ авахуулаад хийх ажил мундахгүй. Гэтэл зуны сарыг зургаа юм шиг санаж наадамласаар анхны цас унахтай зэрэг гэнэт ухаарсан мэт сандардаг арчаагүй малчин өчнөөн бий. Тэгээд өвөл нь болохоор хотоо харлуулчихаад зуд турханд хамаг буруугаа чихээд сууж байх вий.

Сүүлийн үед малаа саадаггүй залхуу малчин олширсон гэж ярьдаг нь үнэний ортой. Одоо хот байтугай хөдөөд цагаан идээ нүүдний гэм болсныг хүн бүр хэлдэг. Бидний багад захын нэг малчныхаар ороход цагаан идээгээр бялхаж байдаг сан. Хотоос ирсэн хамаатнууддаа даавуун ууг дүүрэн хийж өгөөд явуулна. Харин одоо ингэж цагаан идээгээр халгиж цалгисан айл хэр олон байгаа билээ. Монгол 60 сая малтай хэрнээ 15 мянган төгрөгөөр ганц кг мах авч, ааруулын үнэ 20 мянгыг давж, сүүнийхээ 80 хувийг импорттоор авч буй нь эмгэнэл биш гэж үү. Гэвч энэ бүгдийг тоож, анхаарлаа хандуулах ч сөхөөгүй наадамлаж, өдөр хоногийг өнгөрөөсөөр. Ерөнхий сайд анхааруулсаар байтал ийнхүү үл тоосон наадамчин монголчууд байгаль эхийн ниргэлт амсаж байж оройд нь орох гээд байх шиг санагдсан юм. [ЗГМ]

Аймгийн харцага, начингууд хүртэл шинэ цолны мялаалга наадам хийдэг болжээ

Г.Баярсайхан

@bayarsaikhanZGM

Наадам дуусаагүй байхад цас, хадлан яах вэ

Төрийн ордонд болж өнгөрсөн Улсын онцгой комиссын өргөтгөсөн хуралдаан дээр энэ жил өвөлжилт хүндэрч магадгүйг албаны хүмүүс сануулсан. Наймдугаар сард орсон их борооны улмаас ургац хураалт хойшлох, болц удаахрах зэрэг шалтгаанаас хамаарч ургац алдах нөхцөл бүрдсэнийг салбарын яамнаас тариаланчдад анхааруулсан бол наймдугаар сарын сүүл, есдүгээр сарын эхээр цас орж, олон жилийн дундаас хүйтэн өвөл болж магадгүй гэх мэдээллийг цаг уурын

байгууллагаас өглөө. Хуралдааны төгсгөлд Ерөнхий сайд У.Хүрэлсүх найр, наадмын сар дууссаныг сануулж, өвөлжилтийн бэлтгэлээ сайтар хангахыг шаг шатныханд хатуу анхааруулсан. Гэвч эрхэм сайдын үгийг нохой хуцаж байгаан чинээ ч тоох хүн алга. Долдугаар сарын аравдаар улс орон даяар эхэлсэн их найр наадам хичээлийн шинэ жил эхлэх дөхсөн өнөө үед ч үргэлжилсээр. 21 аймаг, 330 сумын наадам ч яахав болдгоороо болоод өнгөрсөн. Харин албан ёсны наадмын дараах албан бус

бэсрэг наадмууд бараг хоёр сарын турш үргэлжилсэн хэрнээ дуусах яагаа ч үгүй байна. Наадам хэссэн монголчуудын тоос шингэрэх ч янз алга.

Улсын баяр наадмаар шинэ цол хүртсэн бөхчүүд түүнийхээ мялаалга наадмыг хийдэг уламжлалыг байх ёстой зүйл гэж үзье. Гэтэл сүүлийн үед аймгийн цолтнууд хүртэл нүсэр том мялаалга наадам хийдэг болжээ. Тэр ч байтугай аймгийн харцага, аймгийн начин цол хүртсэн нөхөд хүртэл бэсрэг наадам хийж, бөх

барилдуулж, морь уралдуулж, сур харваа зохион байгуулж байгааг юу гэж ойлгох вэ. Тун удахгүй сумын заан цолны мялаалга наадам гэж сонсогдоход гайхах зүйл алга.

Жил бүр 120 орчим бөх шинээр аймаг, улсын цол хүртдэг гэх ерөнхий багцаа бий. Энэ жилийн тухайд аймгийн начин 70 гаруй, аймгийн харцага 20 орчим, аймгийн заан тав, аймгийн арслан цолыг 20 шахам бөх хүртжээ. Үүн дээр улсын баяр наадмын шинэ цолтнуудыг нэмбэл 120 гэсэн

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 08 дугаар сарын 23-ний өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 13 дугаар хороо/”-ын ажил

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХААГ-19/135

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 13 дугаар хороо/”-ын ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна. Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 (тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **30 хоногийн** туршид хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, түүний тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг нь тооцож жилийн тоо: Сүүлийн 3 жилийн (2016, 2017, 2018 он) борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.

2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх.

3. Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 оны аль нэг жилд төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх.

Ижил төстэй ажилд барилга угсралтын ажил хийж гүйцэтгэсэн туршлагыг тооцно.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм

Зураг төсөл боловсруулах байгууллага нь дараах тусгай зөвшөөрөл ирүүлнэ.

Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог:

1.2.1. 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)

1.2.4 Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

1.2.5 Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10кВ хүртэл), дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл, орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл

1.2.6 Техник, эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв болон түүнээс дээш

эсвэл

ЗТ-3.1 Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл

ЗТ-8.1 Орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилтийн зураг төсөл

ЗТ-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

ЗТ-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

ЗТ-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл

ЗТ-6.4 Барилга байгууламжийн дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл

ЗТ-11.1 Барилга байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, төсөв болон түүнээс дээш.

Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөл ирүүлнэ.

Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог:

2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт

2.1.2. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил /1-5 давхар хүртэл/

2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт болон түүнээс дээш

эсвэл

БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил

БА-2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил

БА-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-6.4 Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернэт сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт болон түүнээс дээш

Тендерийн баталгааны үнийн дүн: **80,000,000 /наян сая/ төгрөг**

Хүчинтэй байх хугацаа: 2019 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийг дуустал.

Тендерийг **2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 11 цаг 00 минутаас өмнө** системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 11 цаг 20 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх **тооцно.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810

Хүмүүс



Хувцсаа элэгдэж урагдтал нь удаан өмсвөл бүр илүү загварлаг

93//KiDULT-ийн байр гурван хэсгээс бүрдэх аж. Харин дэлгүүр бүхэлдээ эмх цэгцийг мэдрүүлнэ. Хоёр цагаан сандал байх бөгөөд брэнд дэлгүүрийн ширээн дээр хөглөрдөг сэтгүүлээс ганц нь ч энд байхгүй. Бүр лангуу ч үгүй бөгөөд төмөр өлгүүрээс таван хүрэм, нэг юбка өлгөөтэй байх нь сонин. “Манай бүтээгдэхүүнүүд худалдаанд гараад нэг өдрийн дотор зарагдаж дуусдаг. Энэ бол илүү үлдсэн хувцаснууд” хэмээн М.Нямсүрэн хариулав. Учир нь дэлгүүр сард хоёр өдөр л хаалгаа нээдэг аж.

Бусад цагт нь зургаан хүний бүрэлдэхүүнтэй 93//KiDULT-ийн баг загвар зохион бүтээх, үйлдвэрлэх, брэнд хөгжүүлэлтээ хийдэг. Энэ талаар Д.Нямсүрэн “Бидний хамгийн том давуу тал бол гаргасан загвар бүр үлдэгдэлгүй зарагдаж дуусдаг

байдаг. Бид загвараа зохион бүтээх, чанартай материал сонгох, фото зураг авалт хийх, брэнд хөгжүүлэлт, маркетинг сурталчилгаандаа харамгүй цаг зарцуулдаг. Олон тооны хувцас үйлдвэрлэх биш үнэ цэнэ шингэсэн цөөн тооны хувцас үйлдвэрлэхийг зорьдог. Тиймдээ ч KiDULT-ийн хувцаснууд өдөр бүр өмссөн ч уйдахааргүй, урагдсан ч загварлаг харагдах тийм л үнэ цэнэтэй байгаасай гэж бид зорьдог. Хувцсаа элэгдэж урагдтал нь удаан өмсвөл бүр илүү загварлаг. Тиймээс удаан өмсөхөд тохиромжтой чанартай материал ашигладаг. Мөн өнөөгийн нийгэм залуусаас өөртөө итгэлтэй байхыг “шаарддаг” болсон. Тиймээс манай брэнд трендийг бус шинэ содон бас биед эвтэйхэн хувцсыг л санал болгодог” хэмээн ярилаа. Чанарт илүү анхаарсан, цөөн тоог эрхэмлэсэн, эрх чөлөөтэй ч эмх цэгцтэй гэдэг утгаараа KiDULT бол яах аргагүй минималист брэнд юм.

ЗАЛУУСЫН ОРОН ЗАЙ БА МИЛЛЕНИАЛУУДЫН БИЗНЕСИЙН ХЭМНЭЛ KiDULT-ийн үүсгэн байгуу-

лагч Г.Тэнүүн, ахлах загвар зохион бүтээгч М.Нямсүрэн, менежер Х.Жаргалмаа нар бол миллениал үеийнх. Харин туслах дизайнер Р.Цэлмүүн, Б.Энхцацрал нар Z үеийнхэн. Хүний эрхийг тунхагласан ардчилсан нийгэмд хүмүүжиж, технологи, шинжлэх ухааны хурдацтай хөгжилтэй хөл нийлүүлэн яваа шинэ мянганыхан буюу миллениалууд болон Z-үүд өмнөх үеийнхнээс үзэл бодол, амьдралын хэв маягаараа эрхгүй ялгарна.

Уг дэлгүүр сард хоёр өдөр л хаалгаа нээдэг аж

Энэ үеийнхнийг бүх зүйлийг аль болох өөрөөр бас бүтээлчээр хийхийг эрхэмлэдэг хэтэрхий хөдөлгөөнтэй, амбицтай гэж Wellspace сэтгэл судлалын төвийн үүсгэн байгуулагч, сэтгэл судлаач Тара Гриффит тодорхойлсон нь бий.

Niima: Үйлчлүүлэгчдийн маань 90 хувь нь Instagram-аар “дамжин” ирдэг

pekaze. Түүний хамгийн сүүлд хүүтэйгээ хамтдаа авахуулсан зураг гэхэд л 9758 хандалт авчээ.

АЖИЛЛАХ АРГА БАРИЛ БА АЛСЫН ХАРАА

93//KiDULT удахгүй онлайн дэлгүүртэй болно. Улаанбаатарт хүрээгээ тэлж Дархан, Эрдэнэтэд салбартай болохоор зорьж байгаа гэнэ. Д.Нямсүрэн хоногийн 24 цагийн яг хагасыг нь ажилдаа зарцуулдаг. Тэрбээр ойрын хугацаанд ном бичихийг бас Ази, Европын улсуудаар аялахыг хүсч байгаа тухайгаа ярилаа.

“Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд хамгийн их асуудал дагуулсан зүйл юу байв” гэхэд тэрбээр, “Хамтарч ажиллахад тохирсон гал цогтой, хүсэл мөрөөдөлтэй хүмүүс тун цөөхөн байдаг” гэж хариулсан юм. Продакшны хэмжээнд үр бүтээлтэй ажилладаг нь багийн гишүүдийн ажлын бүтээмжтэй холбоотой аж. Үүний нууцыг “багийн гишүүн бүр зорилгоо ухамсарлаж, хамтран ажиллаж чаддаг” гэж тайлбарласан юм. Зургаан гишүүний хоёр нь их сургуулийн оюутан. Бүтэн цагаар биш уян хатан нөхцөлөөр дэмжин ажилладаг нь харилцан ойлголцлыг илтгэнэ. “Цагт хүлэгдэж биш хүсэл мөрөөдлөөрөө хөглөгдөн ажилладаг нь үйлдвэрлэсэн хувцас бүр чанартай байхад нөлөөлдөг” гэж. М.Нямсүрэн тодорхойлов.

СТРЕССИЙГ МЭДЭР БАС СОШИАЛАА ХЯНА

Д.Нямсүрэн хувцас үйлдвэрлэлийн бүх шат дамжлагад хяналт тавьж ажилладаг учир уурлаж, бухимдах тохиолдол их гардаг. Хувцас оёх материалаа чанартай гэж сонгосон ч хэсэг хугацааны дараа бөөсрөх үед сэтгэл санаа “навс” унана. Эсвэл хамтран ажиллаж буй газрууд эхэлж ярьснаа зөрчиж, цаг хугацаа, нөхцөлөө гэнэт өөрчлөх зэрэг хүндрэлүүд олон гарна. Ийм нөхцөлд тэр стрессийг

дарамт биш боломж гэж хардаг гэв. Тэрбээр, “Ажил буцалж байгаа үед асуудал байх л болно. Асуудлыг дагаад стресс үүсэх хэдий ч шийдвэрлээд, эргээд харахад илүү үр бүтээмжтэй ажилласан байдаг. Загварын хувьд шинэ эсгүүр, зохион бүтээлт, шинэ дизайныг туршин хүргэх нь тийм ч амархан байгаагүй. 2017 онд анхны намар, өвлийн загвараа танилцуулахад хүн бүр алга ташин гайхалтайгаар хүлээн авсан. Гэхдээ шинэ, өвөрмөц загваруудыг өмсөөд турших зориг залууст бага байсан учир хувцаснуудаас үлдсэн. Харин өнөөдөр минимал хэв маягтай, том хэлхгэр хэмжээтэй, шинэ загваруудыг маань залуучууд тохирсон гал цогтой, хүсэл мөрөөдөлтэй хүмүүс тун цөөхөн байдаг” гэж хариулсан юм. Продакшны хэмжээнд үр бүтээлтэй ажилладаг нь багийн гишүүдийн ажлын бүтээмжтэй холбоотой аж. Үүний нууцыг “багийн гишүүн бүр зорилгоо ухамсарлаж, хамтран ажиллаж чаддаг” гэж тайлбарласан юм. Зургаан гишүүний хоёр нь их сургуулийн оюутан. Бүтэн цагаар биш уян хатан нөхцөлөөр дэмжин ажилладаг нь харилцан ойлголцлыг илтгэнэ. “Цагт хүлэгдэж биш хүсэл мөрөөдлөөрөө хөглөгдөн ажилладаг нь үйлдвэрлэсэн хувцас бүр чанартай байхад нөлөөлдөг” гэж. М.Нямсүрэн тодорхойлов.

Харин уулзалтын төгсгөлд М.Нямсүрэн залууст социалд “мацаг барих”-ыг санал болголоо. Тэрбээр хэлэхдээ, “Орчин дуурайгаа мэдэрч байсан дарамтыг мэдэрч байна. Залуучууд социалд хэт автсанаас яаргаанд орж байна. Би ч гэсэн ялгаагүй социал дээр олон мундаг хүмүүсийг дагаж тэдэн шиг байхыг хичээж байсан. Дарамтыг мэдэрч байсан. Харин сарын хугацаанд социал мацаг барихдаа би гэр бүлээ, найз нөхдөө бас өөрийнхөө чаддаг зүйлийг олж харсан. Би мундаг хүн биш. Өөрийнхөө чиглэлийг бүрэн олчихсон ч хүн биш. Зөвхөн багаасаа дуртай байсан зүйлдээ цаг гаргаж, өөрийн чаддаг зүйлдээ төвлөрч байгаа хүн. Социал медиад бидний хардаг зүйл чухал биш. Чи мундаг хүмүүсийг хараад, дагч дуурайгаад хэзээ ч өөрийгөө олохгүй. Оюун бодлоо өөрийгөө хайрлахад төвлөрүүлж социалыг зөв ашиглаж сураарай. Хүссэн зүйлээ өөрийнхөөрөө л хий. Социалд бусдыг дагаж байна гэдэг даган дууриах ёстой гэсэн үг биш” гэсэн юм. [31W]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019 оны 08 дугаар сарын 23-ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Тендер шалгаруулалтын нэр:Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажил /БЗД, 5, 19, 22, 24, 27 дугаар хороо/-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХААГ-19/141

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендер оролцогчдоос “Хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажил /БЗД, 5, 19, 22, 24, 27 дугаар хороо/-ыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендер оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.

Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: **Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, түүний тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг нь тооцох жилийн тоо:** Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын борлуулалтын дундаж орлого нь төсөвт өртөгийн 50 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх.

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын аль нэг жилд төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй гэрээний үндсэн гүйцэтгэгчээр доод тал нь 1 удаа ажилласан байх.

Ижил төстэй ажилд Хөрсний ус зайлуулах, үерийн сувагчлалын ажил хийж гүйцэтгэсэн туршлагыг тооцно.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:Тийм

Зураг төсөл боловсруулах байгууллагын хувьд:

Барилга хот байгуулалтын яамнаас олгодог:

1.3.5. Усны барилга байгууламжийн зураг төсөл болон түүнээс дээш эсвэл 3Т-2.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл болон түүнээс дээш эсвэл 3Т-3.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл болон түүнээс дээш эсвэл 3Т-4.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл болон түүнээс дээш эсвэл 3Т-5.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл болон түүнээс дээш

Мөн барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллагын хувьд:

Барилга хот байгуулалтын яамнаас олгодог:

- 2.3.2. Хөрсний ус доошуулах, шүүрүүлэх, эргийн бэхлэгээ, далан суваг үүний дотор төмөр замын далан, хоолой болон газар шорооны тусгай ажил болон түүнээс дээш эсвэл - БА-2.2. Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил болон түүнээс дээш Тендерийн хамт 4,300,000 төгрөг /дөрвөн сая гурван зуун мянга/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 10 цаг 10 минутад Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810

ZGM DAILY

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

Minister of Foreign Affairs Tsogtbaatar Damdin meets U.S. Agency for International Development's Mission Director to the Philippines, Pacific Islands, and Mongolia Lawrence Hardy and Ambassador of the United States to Mongolia Michael Klecheski.

ECONOMY

International credit rating agency Fitch ratings organizes Fitch on Mongolia 2019 forum to discuss Mongolia's mining and banking sector outlook.

Mongolia receives around 215,780 tourists, increasing by 6.4 percent compared to the same period of last year. The number of Taiwanese tourists to travel in Mongolia increased by 30 percent.

Top 20 index rises 0.1 percent, to 19,548.91 points. MSE A index increases 0.49 percent, to 9,080.82 points. MSE B index decreases 1.28 percent, to 7,713.52 points.

SOCIETY

Under the auspices of the President of Mongolia, a campaign The Youth for English was carried out and the closing ceremony took place at the central square on August 21.

Түүнийг тайлбар хүсэхэд Tesla компани хариу өгсөнгүй. Уур амьсгалын өөрчлөлт нь нам дор байрлалтай арлын улсад оршин тогтнохтой холбоотой аюул болж хувираад байна. Дээшилсээр байгаа далайн усны түвшин, улам халуун болж буй агаарын температур, ихэссээр байгаа хур тунадаснаас хамгаалах арга хэмжээнд ирэх зуунд 100 тэрбум гаруй сингапур доллар (72 тэрбум ам.доллар) зарцуулах шаардлагатайг Сингапурын Ерөнхий сайд Ли Сиен Лун өнгөрсөн ням гарагт иргэддээ хандан үг хэлэхдээ онцолсон. Сингапурын галт тэрэг, автобус нь арал улсын 720 ам



станд байгуулах нь хүчир ажил хэмээн тэрбээр анхаарууллаа. “Автомашинь зогсоол байгуулахад ч хэцүү болчлоод байгаа. Дээр нь цэнэглэх станц байгуулах ажил гараад ирлээ. Гэтэл шийдэл нь алга” хэмээн тэрбээр татгалзав.

Энэ сарын эхээр Сингапурт анхны цахилгаанаар цэнэглэх цэгийг шатахуун түгээгүүрийн станцад байгуулснаа Royal Dutch Shell Plc мэдээлсэн. Тус компани 10 дугаар сар гэхэд

Сингапурчуудын 52 хувь нь цэнэглэх зай талбай олдохгүй гэсэн шалтгаанаар цахилгаан машин худалдаж авахаас жийрхэж байгаа.

километр нутаг дэвсгэрийг бараг бүхэлд нь хамардаг. Жолоочгүй цуваа бүхий метроны шинэ чиглэлүүд нээж, зорчигчийн урсгал хамгийн их автобусны шугамуудад дабл-дэкер буюу давхар автобус ашиглаж байна. Нийт зургаа орчим сая хүн амтай тус улс нийтийн шуурхай тээврийн үйлчилгээг сайжруулах замаар 2040 он гэхэд 45 минутаас хэтрэхгүй хугацаанд нутаг дэвсгэрийнхээ хаа ч хүрэх боломж бүрдүүлэхээр зорьж байна.

Зулкифлийн тайлбараас үзвэл, нийтийн тээврийн хэрэгсэлд гол анхаарлаа чиглүүлж буй Сингапур нь plug-in буюу эрчим хүчний сүлжээнд

залгаж цэнэглэдэг цахилгаан автомашин хөгжүүлэх ажлыг ч орхиогүй. Автомашин эзэмших зөвшөөрлийг 10 жилийн хугацаатай олгодог өнөөгийн зохицуулалтыг өөрчлөх замаар цахилгаан тээврийн хэрэгслийн хэрэглээг дэмжих арга байгааг сайд тайлбарласан юм.

“Бензин хөдөлгүүрт машинуудаа 100 хувь цахилгаан машинаар сольж чадсан улс хэрвээ гарах юм бол тэр нь Сингапур байж таарах болов уу” хэмээн Зулкифли өгүүлэв. Гэхдээ хүн амын 85 хувь нь төрийн зохицуулалтаар байгуулсан, оршин суух нягтрал ихтэй орон сууцанд амьдардаг Сингапурын нөхцөлд нийцсэн цахилгаан цэнэглэх

дахиад есийг нэмж байгуулна. Сингапурчуудын 52 хувь нь цэнэглэх зай талбай олдохгүй гэсэн шалтгаанаар цахилгаан машин худалдаж авахаас жийрхэж байгааг Royal Dutch Shell-ийн саяхны судалгаа харуулсан юм.

Зулкифлийн тооцоогоор, цахилгаан машин хэрэглэх нь зай хураагуурыг хаягдал болгох, дахин боловсруулах, зай хураагуурт ашигладаг ховор металлын олборлолтоос үүдэлтэй нүүрстөрөгчийн дам ялгарал гарах зэрэг бэрхшээл ихтэй. Иймд нүүрстөрөгчөөс ангижруулах хэтийн ирээдүй илүү сайн шийдэл нь устөрөгч хэмээн тэрбээр үзэж байна.

Amazon хамгийн том кампусаа Энэтхэгт нээв



Сарита Рай

Дэлхийн цахим худалдааны аварга Amazon компани АНУ-аас гаднах анхны кампусаа Энэтхэгийн өмнөдийн Хайдарабад хотод нээлээ. Нийт 38445 ам метр талбайтай тус кампуст 15,000 хүн ажиллах юм. Amazon-ы хувьд оффисын зориулалттай хамгийн том байгууламж болж буй уг барилга нь тус компани Энэтхэгийн жижиглэн худалдааны салбарт Walmart Inc-тэй ширүүн өрсөлдөх гэж буйн илэрхийлэл юм.

Хонконгийн орлого огцом буурлаа

Женни Юй

Хонконгийн хувьцаа зургадугаар сараас хойш 600 тэрбум ам.доллараар үнээ алдсан нь 2015 оноос хойш тохиолдож байгаагүй бууралт болов. Bloomberg-ийн судалгаанд хамрагдсан шинжээчид 2019 онд үйл ажиллагааны орлого дунджаар 19 хувиар буурна хэмээн тооцоолж байгаа нь Hang Seng индекст багтдаг компаниудын хувьд дэлхийн санхүүгийн хямралаас хойших үнэмлэхүй уналт болж буй юм.

Азид эрэлт ихэссэн тул шоколадны үйлдвэрлэл өснө



Шоколаданд дурлагчдын эрэлт ихэссэнээс Азийн үйлдвэрлэгчид какаоны буурцгийн тариаланг өргөтгөх арга хайж эхллээ. Азийн бүс нутаг дахь какаоны буурцгийн гол нийлүүлэгч, боловсруулагч Индонезийн үйлдвэрлэлийг өсгөх нь чухал байгаа ч модод хөгширч, ургац буурсныг Азийн Какаоны Холбоо тайлбарлав. Азийн какао боловсруулалт 2018 оны эцэс хүртэлх гурван жилд 30 хувиар эрс өсжээ.



Дэлхийн гоо бүсгүйгээр тодорсон үе үеийн ялагч зөвхөн оорийн улсдаа төдийгүй тив дамжин хүмүүнлэгийн үйлсэд манлайлан оролцдог билээ. Miss Universe наадмын өнгөрсөн жилийн ялагч Филиппины гоо бүсгүй Катриона Грей Өмнөд Африкт болсон LGBTQ нийгэмлэгийн зохион байгуулсан ялгаварлан гадуурхах, хүчирхийлэл, харгислалаас зайлэхийн хүний эрхийн төлөөх арга хэмжээнд оролцсон

Мөнгөө өөрөөсөө “хамгаалж”, хуримтлалтай болох шалгарсан аргууд



►10

Ертөнцийн мисс Монголд ирнэ

бол ирэх сард Монгол Улсад хүмүүнлэгийн үйл ажиллагаанд уригдаж, хүрэлцэн ирэхээ илэрхийлээд байгаа аж. Тэрбээр өмгөөлөгч мэргэжилтэй, хөгжмийн боловсролоор магистр хамгаалсан, тулааны урлагийн хар бүстэй, жааз хамтлагийн дуучин, загвар өмсөгч юм байна. ►12

Гишүүний “нүцгэн лайв” хардлага дагуулав

►12



Бэлгийн харилцаа идэвхжихэд дагаад цалин өсдөг

►11



Попууд багтахгүй газар гэж бий



Хэлсэн үг болгон нь уухайлан дэмжих, уриалан түрэх алга ташилтаар хүрээлэгддэг популист улстөрчдөд багтах шингэх зайгүй газар гэж бас байдаг ажээ. Азийн төлөөх Боао форумд Л.Болд, Ж.Батзандан нар хүрэлцэн ирснийг хөтлөгч зарласан ч тэд индэр булаалдан үгээ хэлсэнгүй. НҮБ-ыг толгойлж явсан эрхэм дэлхий нийтэд популистууд ямар хор учруулж буйг шүүмжилсэн үгээ хэлсний дараа манай “эр хоёр загал” гэнэт алга болсон байв. Хүндэт зочны үгийг өөрсдөдөө зориулсан гэж ойлгоод, “эсгий хийх газар нохой хэрэггүй” гэх эртний хэлц үгийг бодон бодон гарч одсон юм биш байгаа. Хэлэлцэж буй сэдвүүдэд толгой хүрэхгүйдээ биш, баримталдаг “бодлоготой” нь нийцэхгүй учраас хурал хаяж гарсан гэж хожим хэвлэлийнхэнд тайлбарлах байх.

В сорьцоо шинжлүүлэх хүсэлт гаргах хугацаа дууслаа

Э.Оюунболд аварга В сорьцоо шинжлүүлнэ гэсэн ч албан ёсоор хандаагүйг Баяр наадмыг зохион байгуулах комиссын дарга, шадар сайд Ө.Энхтүвшин мэдээллээ.

бол В сорьцыг шинжлүүлэх явдал. Гэхдээ шинжилгээнд явуулсан шээсийг хувааж хийсэн хоёр дахь савны лацыг нээн, дахин шинжлэх учраас өмнөхөөс зөрүүтэй хариу ирнэ гэсэн найдвар маш бага. Харин энэ хооронд хүчит аварга сүүлийн арван жилд улсын наадмын үзүүр түрүүний болон шөвгөрсөн нийт бөхийн шинжилгээний хариуг олон

нийтэд дэлгэж, “но-той” бол хуулийн байгууллагаар шалгуулах шаардлага тавиад байна. Учир нь тэрбээр Допингийн эсрэг үндэсний төв, Баяр наадмыг зохион байгуулах хорооны эрх мэдэлтнүүд улс төрийн өндөр албан тушаалтнуудын шууд оролцоотойгоор шинжилгээний хариуг будилаантуулсан гэж үздэгээ илэрхийсэн юм. ►12



Нөхөр маань тоглоомонд донтчихлоо, би яах вэ?



►11

Трампын хүү Монголд ан хийхээр ирсэн үү




АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трамп хилээр ховор ан амьтны мах, арьс, эд эрхтэн оруулах хоригийг зөөллөсөн шийдвэр гаргасан нь ихээхэн шүүмжлэл дагуулж байв. Энэ шийдвэрийн улмаас Африкт хориотой ан хийх үзэгдэл ихэссэн гэж үзэх хэсэг байхад ангийн хорхойтой хөвгүүдээ

“эрхлүүлж” ийм шийдвэр гаргасан гэж цухалдах хүмүүс бас байсан. Харин энэ удаад түүний хүү Дональд Трамп Жуниор Монголд ирэнгүүтээ дархан цаазат ангаар баялаг баруун хязгаарыг зорьсон нь дэлхий даяар шуугисан асуудалтай холбож хардахад хүргэлээ. ►12

Залуу аваргыг допинг хэрэглэсэн гэх хардлагаас “аврах” ганц гарц

Баяжих ухаан



Монголын дундаж орх 1.2 сая төгрөгийн орлоготой тухай Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Энэ бол өмнөх оноос 200-аад мянган төгрөгөөр өссөн дүн. Орлогын түвшин инфляцаас хурдтай өссөн нь бидний хэмнэх, хадгалах, хуримтлалаа нэмэгдүүлэх боломж сайжирч байгааг илтгэнэ. Гэсэн ч мөн хугацаанд өрхийн зарлага нь орлогоосоо ч, улсын инфляцаас ч илүү хурдтай өсч 1.3 сая төгрөгтэй тэнцжээ. Өөрөөр хэлбэл Монголын дундаж орх сар бүрийн зардлаа санхүүжүүлэхийн тулд тогтмол 100 мянган төгрөгийн өрөнд орж байна гэсэн үг.


Орлого нэмэгдэхийн хэрээр шаардлагагүй зардлаа өсгөдөг, материаллаг хэрэглээнд суурилсан бидний санхүү удирдлагын сул талыг зөвхөн энэ жишээнээс харж болно. Санхүүгээ удирдахдаа монголчуудын нийтлэг гаргадаг алдаануудыг Монголбанк тодорхойлсон байдаг аж. Бид хэрэглээг хэт шүтсэн, хэмнэх дадал суугаагүй, хэмнэснээ хуримтлуулах дадал суугаагүй, хуримтлуулах арга эзэмшээгүй, бэлэнчлэх сэтгэлгээтэй, санхүүгийн боловсрол муу (АНУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудаас бараг хоёр дахин сул), санхүүгийн сахилга бат сул зэрэг тодорхой алдаануудыг гаргадаг байна.

ЯГ ОДОО ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖ НЭЭ!

Бид хугацаатай хадгаламж нээхээс эмээх хандлагатай байдаг. Гэнэтийн санхүүгийн хэрэгцээ гарахад гар дээр хөрвөх чадвартай бэлэн мөнгө байхгүй байх вий гэх айдсаас энэ нь үүсэлтэй. Гэвч энэ айдас нь мөн л хэрэглээг хэт шүтсэн хандлагатай маань холбоотой. Сүүлийн 10 жилд Монгол өрхийн мөнгөн орлого гурав дахин нэмэгдсэн байна. Мөнгөн зардал инфляцаас илүү эрчтэй, орлоготой параллель өсч ирснээс орлогын өсөлт шууд хэрэглээ болж "лангууруу" гарч байгааг харж болно. Тэгэхээр бидний хадгаламжиндаа хийгээгүй мөнгө зайлшгүй гэнэтийн хэрэгцээнд бус шуналыг маань тэжээхэд л зарцуулагдах нь илүү түгээмэл байдаг байна.

ДАНСНААСАА ТОГТМОЛ ШИЛЖҮҮЛЭГ ХОЛБУУЛАХ

Хадгаламжийн данс нээх бол өрдөө эхлэл. Нэг сарын цалинд ч хүрэхгүй үлдэгдэлтэй хадгаламжтай хүмүүсийг алийг тэр гэх вэ. Тиймээс ажил хийж олсон орлогоо өөрөөсөө "хамгаалж" хуримтлал болох



Орлого өссөн ч хуримтлал үүсгэж чадахгүй байгаа энгийн монгол өрхийн жишээ танд ойр санагдаж байвал дараах мэдээлэлд анхаарлаа хандуулаарай. Орох мөнгөн урсгал тогтмол үед хуримтлал үүсгэх, монгол өрхийн санхүүгийн сахилга бат, орлогоо захиран зарцуулах хэв маягт тусгайлан нийцсэн, өдөр тутмын амьдралдаа нэвтрүүлж болохуйц энгийн аргуудыг танилцуулж байна.

шулуун, дардан замыг бий болгох хэрэгтэй.

Standard & Poor's байгууллага Дэлхийн банк болон Жорж Вашингтоны их сургуулийн судалгааны багтай хамтран хийсэн Дэлхийн улс орнуудын санхүүгийн мэдлэг, сахилга батыг тодруулах судалгаанд Монгол улс 41 оноо авсан бол АНУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудад энэ үзүүлэлт 57 хувьтай байжээ. Санхүүгийн

Мөнгөө өөрөөсөө хамгаалж, хуримтлалтай болох шалгарсан аргууд

сахилга бат сул үед харьцангуй харгис гэж тодорхойлогддог аргууд илүү үр дүнтэй байдаг. Хуримтлал үүсгэхийн тулд өөрийн цалингийн данснаасаа сар тутамд, цалин буудаг өдрөө тааруулан тогтмол шилжүүлэг хийх тохиргоо суулгахад хангалттай. Цалингаа буунгуут, магадгүй оффисоосоо гарахаасаа ч өмнө тогтмол шилжүүлгийг тань татчихдаг бол бүр сайн.

ХУДАЛДАЖ АВАХ ЗҮЙЛСИЙНХЭЭ ЖАГСААЛТЫГ БИЧИЖ БАЙХ

Европын орнуудтай харьцуулахад Азийн орнууд, тэр дундаа монголчуудын дунд сэтгэл хөдлөлд тулгуурласан худалдан авалт хийх нь илүү түгээмэл байдаг. Бусад орнуудтай харьцуулахад бид төдийлөн шаардлагагүй, хэв маяг, хэлбэрт хөтөлгөсөн худалдан авалт хийх нь их байдаг гэсэн үг. Хэрвээ та санал нийлэхгүй байгаа бол шүүгээндээ сүүлийн 3 сар нэг ч удаа хэрэглээгүй хувцас, гутал, цүнх зэрэг байгаа эсэхийг анзаараад нэг үзээрэй.

Замбараагүй худалдан авалтаас гадна дэлгүүр, супермаркетууд биднийг төлөвлөөгүй худалдан авалт хийлгэхэд зориулагдсан зохион байгуулалттай байдаг. Нэг ширхэг давс авахаар дэлгүүр ороод тор дүүрэн бараатай гарч ирж үзсэн л биз дээ. Тэгвэл та тогтмол хэрэглэдэг дэвтэр дээрээ, эсвэл гар утсан дээрээ жагсаалт үүсгэн, худалдан авах шаардлагатай зүйлсээ тухай бүр нь тэмдэглэж хэвшээрэй. Ингэснээр нэг талаас дутуу худалдан авалт хийж, олон дахин дэлгүүр явахаас сэргийлнэ, нөгөө талаас шаардлагагүй зүйлс худалдан авахгүй байх боломжтой.

ХУДАЛДАН АВАЛТАА АЛЬ БОЛОХ БЭЛЭН МӨНГӨӨР ХИЙХ

Худалдаа, үйлчилгээний газрууд бараг бүгд бэлэн бусаар гүйлгээ хийх боломжтой болсон нь Монгол Улсын хувьд санхүүгийн том дэвшил. Бэлэн бусаар гүйлгээ хийх нь ариун цэвэр, аюулгүй байдлын хувьд гээд олон давуу талтай. Гэхдээ хэрвээ та мөнгө хэмнэхээр хичээж байгаа бол тийм ч тохиромжтой зүйл биш. АНУ-д хийгдсэн судалгаагаар, нэг сарын хугацаанд бэлэн бус гүйлгээнээс татгалзах, зөвхөн

бэлэн мөнгөөр худалдан авалт хийхэд судалгаанд оролцогчид зардлаа 18 хүртэл хувиар бууруулж чаджээ. Энэ нь бэлэн мөнгөөр худалдан авалт хийх нь хүний сэтгэл зүйд асар хүчтэй нөлөө үзүүлдэгтэй холбоотой. Хэдий их хэмжээний худалдан авалт хийсэн ч карт зуруулахад бидний тархинд төдийлөн хүчтэй дохио очдоггүй байна. Харин зарцуулж буй мөнгөө нэгбүрчлэн тоолж, бусдад өгөх тэр үйлдэл нь тархинд асар хүчтэй сигнал өгдөг байх нь.

ЕВАРИМТ-АА ӨДӨР БҮР БҮРТГҮҮЛЖ БАЙХ

/Цүнх, түрийвчээрээ дүүрэн баримт цуглуулчихаад, сугалааны тохирол явагдахын өмнөх өдөр л бүртгүүлдэг олон хүний нэг юм биш биз. Хэрвээ тийм бол та орой бүр ebarimt—аа уншуулж хэвшээрэй. Ингэснээр та далд ухамсартаа нэг л өдөрт ямар их хэмжээний зарцуулалт хийж байгаагаа ойлгуулж байгаа юм. Тодорхой хугацааны дараа таны уншуулах баримтын тоо цөөрч байгааг та анзаарах болно.

ХУРИМТЛАЛЫНХАА ТӨЛӨВЛӨГӨӨГ ГАРГА

Ямар ч том зорилгыг алхам алхмаар нь нарийвчилчихвал хүрэхэд тийм ч хэцүү биш. Нийт хуримтлалынхаа зорилгыг тогтоогоод, тухайн зорилгод хүрэх хугацаагаа тодорхойлоод, сар тутамд хуваачихвал таны сарын, өдрийн зорилт маш тодорхой болоод ирнэ. Гүйцэтгэлээ тухай бүр хянаад, том зорилгодоо хүрэхэд ямх ямхаар ч атугай ойртож байгаагаа мэдрэх амттай биш гэж үү.

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН ХЭРЭГЛЭДЭГ БОЛ ХУРУУНЫ ХЭЭ, ЭСВЭЛ НҮҮР ТАНИХ ТЕХНОЛОГИОР НЭВТРЭХ ТОХИРГООГ БҮҮ ИДЭВХЖҮҮЛ

Уншигч та хуримтлалын хамгийн гол дайсан нь бид өөрсдөө, мөн бидний замбараагүй хэрэглээ, амьдралын буруу хэвшил гэдгийг ойлгосон байх. Санхүүгийн сахилга бат муутай байх тусмаа мөнгөө өөрөөсөө хамгаалах "харгис" аргуудыг хэрэглэх нь оновчтой. Технологийн дэвшил бидэнд хэрэглээний асар хялбар практикыг

санал болгож байна. Энэ нь өөрөө хэрэглээг урамшуулах, ухамсаргүй зарцуулалт хийх том шалтгаан болоод байгаа юм. Тиймээс хэрвээ та гар утасны аппликейшн ашигладаг бол хурууны хээ, эсвэл нүүр таних технологиор нэвтрэх тохиргоог бүү идэвхжүүлээрэй. Зарцуулалт хийх болгондоо олон үсэг, тооноос бүрдэх нууц үгээ шивж оруулах ядаргаатай биш гэж үү. Тэгснээс худалдаж аваагүй байсан нь дээр.

ТӨЛӨВЛӨГДӨӨГҮЙ ГЭНЭТИЙН ОРЛОГЫГ ЗҮГЭЭР Л МАРТ

Сар тутмын тогтмол орлогоос гадна нэмэлт орлого орж ирвэл түүнийгээ зүгээр л мартаад хадгаламжиндаа хий. Мэдээж санхүүгийн сахилга бат илүү сайн үед хааяа өөрийгөө урамшуулж, удаан хугацаанд авахыг хүссэн зүйлээ авахыг зөвшөөрдөг ч худалдан авалт худалдан авалтаа өдөөдөг гэдгийг мартаж болохгүй. Тиймээс тодорхой хэмжээний хуримтлалтай болох хүртлээ гэнэтийн том худалдан авалтаас ч зайлсхийх хэрэгтэй.

ЭРҮҮЛ ХООЛЛОЖ, ЭРҮҮЛ БАЙХ

Та сүүлийн нэг жилийн хугацаанд төлөвлөгдөөгүй хэрнээ хойшлуулшгүй гэнэтийн зардал юунд гаргаснаа санах гээд үз дээ. Монголчууд эрүүл мэндийн хэрэглээндээ хамгийн их гэнэтийн зардал гаргадгийг судалгаагаар тогтоосон байдаг. Тиймээс тогтмол эрүүл хооллож, өөрийгөө хайрлан аль болох өвдөхгүй байх нь гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүрэг тань байхаас гадна хуримтлал үүсгэхэд маш чухал хүчин зүйл юм шүү.

Зөвлөгөө хэдий сайн ч хэрэгжүүлэхгүй бол ямар ч үр дүнгүй. Тиймээс та эдгээрээс өөрийн амьдралын хэв маягт тохирохыг сонгож яг өнөөдрөөс хэрэгжүүлээрэй. Нэг жилийн дараа та өнөөдөр эхэлсэн өөртөө талархах болно.

ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ХОХИРООСОН ҮЙЛ ЯВДАЛ, АЛБАН ТУШААЛТНЫ ЗҮЙ БУС ҮЙЛДЭЛ, НИЙГМИЙН АНХААРЛЫГ ТАТСАН АЛИВАА МЭДЭЭЛЭЛ, БАРИМТ, ЗУРАГ ЗЭРГИЙГ

▶ 10,000.000 ХҮРТЭЛ ТӨГРӨГӨӨР ХУДАЛДАЖ АВНА.

[ЗГМ СОНИН]

УТАС: 70103131 | ИМЭЙЛ: INFO@ZGML.MN

ТЭРБУМТАН ЗӨВЛӨЖ БАЙНА

Том сэтгэ. Бид илүү том зүйлийг мөрөөдөж, том зорилго тавих тусмаа өөрийгөө илүү дайчилдаг. Харамсалтай нь ихэнх тохиолдолд бидний ирээдүйн төсөөлөл өнгөрсөн амьдралын маань тусгал байдаг аж. Өөрөөр хэлбэл, өнгөрсөнд томоохон амжилт гаргаж байгаагүй бол ирээдүйдээ ч том зүйлийг бүтээж чадахгүй гэж эндүүрдэг. Харин энэ үед эргэн тойрноо хар гэж Apple-ийн үүсгэн байгуулагч Стив Жобс зөвлөдөг байна. Бидний эргэн тойронд байгаа суут бүтээлүүд, өдөр тутамдаа ашигладаг зүйлсийг бидэн шиг л энгийн хүмүүс бүтээсэн гэдгийг анзаарах хэрэгтэй. Өөрсдийн сэтгэхүйгээ ингэж өөрчилснөөр амжилтад хүрэх эхний алхмаа тавилаа гэсэн үг.

Жефф Бэзос дэлхийн анхны их наядтан болно

2019 оны байдлаар дэлхийн нийт тэрбумтнууд нийлбэр дүнгээрээ 10-аад их наяд ам.доллар эзэмшиж байна. Энэ дундаас хамгийн чинээлэг нь Amazon компанийн үүсгэн байгуулагч Жефф Бэзос бөгөөд хөрөнгө нь 12 оронтой тоогоор үнэлэгдэх болсон дэлхийн анхны хүн юм. Bloomberg-ийн тэрбумтнуудын индекс түүний араас Билл Гейтс



бичигдэж байгаа ба зөвхөн тэд л дэлхий дээр 100 тэрбум давсан хөрөнгөтэй. Харин одоогоос 10 гаруйхан жилийн дараа буюу 2030 он гэхэд дэлхийн анхны долларын их наядтан төрнө гэж Fin24 тооцоолжээ. Энэ жагсаалтыг мөн л Жефф Бэзос тэргүүлж, 66 насандаа дэлхийн анхны их наядтан болох тооцоо гарчээ.

Сэтгэлзүйн булан

Нөхөр маань ТОГЛООМОНД ДОНТЧИХЛОО, БИ ЯАХ ВЭ?



ZGM weekend мэргэжлийн сэтгэлзүйчидтэй хамтран зөвлөгөө өгч байна. Энэ удаагийн дугаарт “Монгол билл” сэтгэл судлалын төвийн сэтгэл судлаач Б.Чоймаа уншигчдаас ирсэн асуултад дараах харилцалтыг өглөө. Хэрэв танд гэр бүл, сэтгэл зүйн тулгамдсан асуудал байвал манай сонинд хаяглан ирүүлээрэй.

ГЭР БҮЛ ХУУРАЛТ ДУТУУГИЙН МЭДРЭМЖЭЭС ҮҮДЭЛТЭЙ

САЙН БАЙНА УУ. БИ 37 НАСТАЙ ЭРЭГТЭЙ. МАНАЙХ ХОЁР ХҮҮХЭДТЭЙ. ХАРИН МАНАЙ ЭХНЭР ГЭР БҮЛЭЭСЭЭ САЛСАН НЭГ ЗАЛУУТАЙ НАМАЙГ ХУУРЧ БАЙСНЫГ ХЭДЭН САРЫН ӨМНӨ МЭДСЭН ЮМ. ТЭР ЗАЛУУГИЙН САЛСАН ЭХНЭР НАДАД ҮНЭНИЙГ ХЭЛЭХЭД БИ ИХ ЦОЧИРДСОН. ЭНЭ ТАЛААР ЭХНЭРТЭЙГЭЭ ЯРИЛЦАЖ ХОЛБООГОО ТАСАЛ ГЭЖ ХЭЛСЭН. БОСГОСОН АМЬДРАЛАА НУРААХЫГ, ХОЁР ХҮҮХЭДЭЭ ХАГАЦАЛ ҮЗҮҮЛЭХИЙГ ХҮСЭХГҮЙ БАЙНА. ГЭТЭЛ ЭХНЭР МААНЬ “ХОЁУЛАА САЛТЯ” ГЭЖ ХЭЛЛЭЭ. БИ ОДОО ЯАХ ЁСТОЙ ВЭ?

Гэр бүлээс гадуурх харилцаа нь ихэвчлэн хамтрагчаасаа авч чадаагүй дутуугийн мэдрэмжтэй холбоотой байдаг. Эхнэр эсвэл нөхрөөсөө авч чадахгүй байгаа мэдрэмжээ өөр хүнээс авах нь энэ харилцааны эхлэл болдог. Тиймээс эхлээд танд ямар асуудал байсан бэ. Эхнэртэйгээ яаж харьцдаг байсан болон эхнэр чинь таниас юу хүсэж хүлээдэг байсан талаар бодоод үзээрэй. Хэн хэн нь тайвширсны дараа ярилцах хэрэгтэй. Уур бухимдал сэтгэлийн хөдөлгөөнөөр асуудлыг шийдэхгүй шүү дээ. Эхнэр чинь тухайн хүнтэй яагаад хамт байхыг хүссэн юм бол, эхнэртэй ямар мэдрэмж сэтгэлийг өгч чадаагүй вэ зэрэг хэн хэнийхээ учир шалтгаан нөхцөлийг нээлттэй ярилцаж тодруулах хэрэгтэй. Асуудлын учир шалтгааныг тодруулсан бол яагаад салахыг хүсэж байгаа, яагаад салахыг хүсэхгүй байгаа шалтгаануудаа ярилцан асуудал

явал шийдэгдэх боломжтой гарц гаргалгааг хамтдаа хайгаарай.

ХҮҮХДҮҮДЭЭ БҮҮ ХАРЬЦУУЛ

БИ ОДОО ХОЁР ОХИНТОЙ. ТОМ МААНЬ НАЙМАН НАСТАЙ, БАГА НЬ ЗУРГААН НАСТАЙ. ДҮҮ НЬ ИХ СЭРГЭЛЭН ЦОВОО ХӨДӨЛГӨӨНТЭЙ, ХҮМҮҮСТЭЙ АМАРХАН НӨХӨРЛӨДӨГ БОЛ ЭГЧ НЬ ЧИМЭЭГҮЙ, ДУУ МУУТАЙ ХҮҮХЭД. ХҮМҮҮСТЭЙ ХУРДАН ДОТНОСОЖ ЧАДДАГГҮЙ ДУУ СУЛТАЙ, НООМОЙ. БИ ТОМ ОХИНДОО САНАА ЗОВООД БАЙНА. ДҮҮ ШИГ НЬ СЭРГЭЛЭН, ХҮМҮҮСТЭЙ НЭЭЛТТЭЙ БОЛЖОХ БОЛОХ УУ. ЯАЖ ТЭГЭХ ВЭ?

Эцэг эхчүүдийн гаргадаг нэг алдаа нь хүүхдүүдээ хооронд нь харьцуулж бодох юм. Хүүхэд бүр өөрийн гэсэн онцлогтой, өөрийн гэсэн зан чанартай. Чимээгүй, дотогшоогоо байлаа гээд хүчээр нээлттэй болгох гэж хүчлэх нь хүүхэд нь дарамт болж өөрийнхөөрөө байж чаддаггүй, дургүй болох ч талтай. Улмаар өөрийг нь ойлгодог хүн байхгүй мэт санагдаж ганцаардахад хүргэнэ. Та хүүхдээ өөртэйгөө дотно, нээлттэй байгаасай гэж хүсэж байвал өөрчлөх гэж хүчлэхгүйгээр өөрийнх нь онол, зан чанарыг хүлээх зөвшөөрөх хэрэгтэй. Тэд чинь нэг хэвэнд цутгасан робот биш, байгаагаараа хайрлагдаж гэж ирсэн хүүхдүүд шүү дээ.

ӨСВӨР НАСАН ӨӨРИЙГӨӨ БУРУУТГАХ МЭДРЭМЖ НЭМЭГДДЭГ

САЙН БАЙНА УУ. БИ ГЕРМАНД СУРДАГ, 17

НАСТАЙ ЭРЭГТЭЙ. НАДАД К-РОР МАШ ИХ ТААЛАГДДАГ УЧИР СОЛОНГОС ХЭЛ СУРСАН. ХАРИН САЯХНААС СОЛОНГОС ОЧИЖ СУРАХЫГ МАШ ИХ ХҮСЧ БАЙНА. УЛС ОРОН БҮРИЙН ӨӨРИЙН ОНЦЛОГ ГЭЖ БАЙДАГ ДАА. ГЭХДЭЭ ЭНЭ БОДЛОО ЭЭЖ, ААВДАА ХЭЛЭХЭЭС АЙГААД БАЙХ ЮМ. ТЭД НАМАЙГ ЭНД СУРГАХ ГЭЖ ИХ ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ ГАРГАСАН. БИ ЯАЖ ӨӨРИЙГӨӨ ОЙЛГУУЛАХ ВЭ?

Тухайн улсын урлаг соёл таалагдаад тэр орныхоо хэлийг судалж байгаа нь сайн хэрэг. Гэхдээ энэ улс чиний ирээдүйн амьдрал, мөрөөдөлд бүрэн хамааралтай эсэхийг бодож үзээрэй. Юун түрүүнд суралцах орон, сургуулиас илүү сурахыг хүсэж буй мэргэжлээ тодорхойлоорой. Чи ирээдүйд ямар амьдралаар, юу хийж амьдрахыг хүсэж байна вэ, тэр амьдралаараа амьдрахад чамд ямар ажил, мэргэжил хэрэгтэй вэ. Энэ мэргэжлээр сурахад надад ямар сургууль, ямар улс тохиромжтой вэ гэх мэтчилэн бодож үзээрэй. 12-16 нас бол шилжилтийн нас. Хүүхдийн онцлогоос хамаарч шилжилтийн нас хожуу тохиох нь ч бий. Тиймээс өөрийн сэтгэл зүй, насны онцлогоо тунгаагаад үзээрэй. Чиний насан дээр нийгмийн мэдрэмж нэмэгдэж бусдыг хүндлэх, бусдын өмнө хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарлаж эхэлдэг. Энэ хэрэг гэр бүлийнхэн, дотны хүмүүстэй тулгарсан болохгүй, бүтэхгүй зүйлийн өмнө өөрийгөө буруутган эмзэглэж, гутрах нь ихэснэ. Эсрэгээрээ өөрийнх нь туслалцаатай бүтсэн ажил хэрэгт баярлаж, урам зориг, эрч хүч авдаг. Тиймээс өөрийгөө буруутгах мэдрэмж чамд байнга төрж байвал хүндээр хүлээн авах хэрэггүй. Сэтгэл зүйгээ тогтвортой байлгах үүднээс

тэмдэглэл хөтөлж болно. Дараа нь уншиж үзээд өөрийнхөө бодол санаанд дүгнэлт хийгээрэй. Мөн аав, ээжтэйгээ өөрт төрж буй мэдрэмжээ хуваалцаж нээлттэй ярилцаад үз. Тэд чамд хамгийн сайн зөвлөгөөг өгөх болно.

УНТСАН Ч АМРААГҮЙ МЭДРЭМЖ ТӨРӨХ НЬ СЭТГЭЛ ЗҮЙТЭЙ ХОЛБООТОЙ

БИ 40 НАСТАЙ ЭМЭГТЭЙ. СУҮЛИЙН ЗУРГААН САР ҮРГЭЛЖ ДӨРВӨН ЦАГТ СЭРЖ БАЙНА. ОРОЙ БОЛОХООР УНТАЖ ЧАДАХГҮЙ ХӨРВӨӨГӨӨД БАЙХ ЮМ. ЭНЭ НЬ СЭТГЭЛ ЗҮЙТЭЙ ХОЛБООТОЙ ЮУ. ХЭРХЭН НОЙРОНДОО САЙН БОЛОХ ВЭ?

Тийм ээ, нойргүйдэх, нойронд муу болох, унтсан ч унтаагүй мэт мэдрэмж төрөх нь сэтгэл зүйтэй холбоотой байдаг. Удаан хугацаагаар ямар нэг зүйлд санаа зовох, түгшүүртэй байх болон хэт их зүйлсийг бодож шаналах нь нойргүйдэлд хүргэдэг. Нойргүй болсон хүмүүс ихэнх нь ямар асуудлаас болж нойронд муу болсноо мэддэггүй. Сэтгэл гутрал нь далд хэлбэрээр удаан хугацаанд бага багаар хуримтлагдсаар хожуу илэрч байгаа нь энэ юм. Асуудлыг хэт хүндээр хүлээж авч удаан хугацаанд шаналахаа болих хэрэгтэй. Асуудал, хэцүү зүйлсээ овоолон үүрч явах биш тухайн цаг үед нь үлдээж сурах нь өнгөрснөө чирж өөрийгөө шийтгэхээс дээр байх болно. Хэрвээ та асуудлаа тодорхойлж чадахгүй байвал мэргэжлийн сэтгэл зүйчийн тусламж аваарай.

ТОГЛООМОНД ДОНТСОН БОЛ СЭТГЭЦИЙН ЭМЧИД ЯАРАЛТАЙ ҮЗҮҮЛ

САЙН БАЙНА УУ. БИ 26

НАСТАЙ, ЭМЭГТЭЙ. МАНАЙ НӨХӨР ТОГЛООМОНД ДОНТЧИХЛОО. БИ ТОГЛОМООС НЬ ХӨНДИЙРҮҮЛЭХ ГЭЭД ХҮҮХДЭЭ ӨВӨР ДЭЭР НЬ АВААЧИЖ ТАВЬСАН Ч УЙЛУУЛААД Л ТОГЛООД БАЙДАГ. НЭГ ӨДӨР БИ КОМПЬЮТЕРИЙН ЗАЛГУУРУУДЫГ НЬ НУУЧИХСАН ЧИНЬ АЙМШИГТАЙ УУРЛАСАН. ЭНЭ ХҮН ТАКСИНД ЯВЖ ӨДРИЙН ХООЛОО ОЛЧИХООД Л ТОГЛООД

ХЭВТЭЖ БАЙХ САНААТАЙ БАЙХ ШИГ БАЙНА. ЯАЖ ЗАСАЖ АВАХ ВЭ?

Мэргэжлийн сэтгэл мэдрэлийн эмчид үзүүлэхийг санал болгож байна. Цахим тоглоом хэт их тоглох нь дэлгэцийн донтолын нэг төрөл бөгөөд даамжирвал сэтгэл мэдрэлд нөлөөлж эмгэг болох аюултай байдаг. Тиймээс сэтгэцийн эмчид үзүүлэн эмчилгээ хийлгэх, шаардлагатай тохиолдолд албадан эмчилгээнд явуулах хэрэгтэй болно.

Бэлгийн харилцаа идэвхжихэд дагаад цалин өсдөг

Бонны их сургууль дахь Хөдөлмөрийн хүрээлэнгийн судалгаагаар хүмүүс бэлгийн харилцаанд олон орох тусам орлого нь нэмэгддэгийг тогтоожээ. Өмнөх олон судалгаагаар хүний аз жаргал хэр төгмөл бэлгийн харьцаанд ордгоос хамаардгийг нотолсон байдаг. Тэгвэл энэ удаа бэлгийн дур хүсэл болон цалин хоорондын харилцан хамаарлыг судалжээ. Энэхүү шинэ датаг 2008 онд Грекийн хүн амд хийсэн судалгаанаас нэгтгэн гаргасан. Үр дүнд нь хүний орлого бэлгийн амьдралын идэвхээс шууд эерэг хамааралтай өсдөг болохыг баталсан байна.

Тэдний тогтоосноор 26-50 насны грекчүүдийн дунд идэвх тодорхой хэмжээнд нэмэгдэхэд,

цалин мөн дагаад 5.4 хувиар ихэсдэг аж. Ямар нэг бэлгийн харилцаанд ордоггүй гэрлэсэн эрэгтэй 1.3 хувиар бага цалин авч байсан ба энэ зүй тогтол нь бэлгийн чиг хандлагаас хамаарч ялгаатай байна гэсэн ойлголт байхгүй.

Гэвч илүү их секс хийснээр шууд л баян болчихно гэсэн үг ердөө ч биш юм. Харин энэхүү шинэ ойлголтыг гаргаж ирсэн судлаачдын үзэж байгаагаар идэвхтэй сексийн амьдрал нь хүний эрүүл мэндэд эергээр нөлөөлөхөөс гадна, аз жаргалын гормоны ялгаралтыг дэмжиж, баг хамт олонтойгоо илүү найрсаг харьцах, асуудлыг эергээр харж, үр дүнтэй шийдэл санал болгох зэрэг замаар тушаал дэвших хүртэл эерэг нөлөөтэй байдаг аж.



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019 оны 08 дугаар сарын 23-ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны дулааны насос станц 2-ын зүүн талын хөрсний ус, Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны дулааны шугам, худгийн хөрсний усыг тогтоох барилга байгууламжийн ажил /ЧД, СБД/-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХААГ-19/143

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос “Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны дулааны насос станц 2-ын зүүн талын хөрсний ус, Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны дулааны шугам, худгийн хөрсний усыг тогтоох барилга байгууламжийн ажил / ЧД, СБД/-ыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон турслалтын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: **Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, түүний тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг нь тооцох жилийн тоо:** Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын борлуулалтын дундаж орлого нь төсөвт өртөгийн 50 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх.

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын аль нэг жилд төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй гэрээний үндсэн гүйцэтгэгчээр доод тал нь 1 удаа ажилласан байх.

Ижил төстэй ажилд Хөрсний ус зайлуулах, үерийн сувагчлалын ажил хийж гүйцэтгэсэн туршлагыг тооцно.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:Тийм

Зураг төсөл боловсруулах байгууллагын хувьд:

Барилга хот байгуулалтын яамнаас олгодог:

1.3.5. Усны барилга байгууламжийн зураг төсөл болон түүнээс дээш эсвэл 3Т-2.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл болон түүнээс дээш эсвэл 3Т-3.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл болон түүнээс дээш эсвэл 3Т-4.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл болон түүнээс дээш эсвэл 3Т-5.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл болон түүнээс дээш

Мөн барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллагын хувьд:

Барилга хот байгуулалтын яамнаас олгодог:

- 2.3.2. Хөрсний ус доошуулах, шүүрүүлэх, эргийн бэхлэгээ, далан суваг үүний дотор төмөр замын далан, хоолой болон газар шорооны тусгай ажил болон түүнээс дээш эсвэл

- БА-2.2. Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил болон түүнээс дээш

Тендерийг 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 10 цаг 30 минутад Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15, Нийслэлийн Засан Захиргааны 4 дүгээр байр, 10 давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810

Нийгмийн сонин сайхан

Хоёр дахь сорьцын хариу ирсний дараа хэн гэдэг бөх допинг хэрэглэснийг шууд зарлах учиртай.

В сорьцоо шинжлүүлэх хүсэлт гаргах хугацаа дууслаа




Тэрээр “Допингийн эсрэг үндэсний төв, Баяр наадмыг зохион байгуулах хорооны эрх мэдэлтнүүд, улс төрийн өндөр албан тушаалтнуудын шууд оролцоотойгоор шинжилгээний хариуг будилаантуулсан талаарх ам дамжсан яриа түгээмэл байдаг” хэмээн төрийн албаныхныг буруутгаад, “өөрийн ДНХ /DNA/-ийн шинжилгээг хийлгэнэ” гэв.

Допинг илэрсэн гэх хардлагын үзүүр Э.Оюунболд аварга руу эргэлтгүй чиглэсэн энэ үед В сорьцоо л шинжлүүлж хэрэглээгүйгээ нотлох ганц гарц үлдсэн байлаа. Гэтэл залуу аварга тэрхүү шинжилгээг нүүр бардам өгөхийг хүссэнгүй, элдэв мэдэгдэл хийж, шаардах бичиг өргөн хэсэг манаргалаа. Хэрэв В сорьцыг шинжлүүлэх хүсэлт гаргаагүй бол хариуг олон нийтэд шууд зарладаг. Допинг илэрсэн гэх хоёр бөхийн В сорьцоо

шинжлүүлэх хүсэлт гаргах сүүлчийн хугацаа нь нөгийг нь өчигдрөөр дуусч, нөгөө нь өнөөдөр буюу наймдугаар сарын 23-ны 18 цагаар дуусгавар болох аж. Харин дугаар шилжих мөч хүртэл хэн ч В сорьцоо шинжлүүлэх албан ёсны хүсэлтээ гаргаагүй л байв. Харин Э.Оюунболд аварга В сорьцоо шинжлүүлнэ гэсэн ч албан ёсоор хандаагүй байгааг Баяр наадмыг зохион байгуулах комиссын дарга, шадар сайд

Ө.Энхтүвшинээс тодруулж мэдлээ. Хэрэв В сорьцыг шинжлүүлэх хүсэлт өгвөл эцсийн хариу 14-21 хоногийн дараа буюу есүгээр сарын 5-12-ны хооронд ирэх юм. Хоёр дахь сорьцын хариу ирсний дараа хэн гэдэг бөх допинг хэрэглэснийг шууд зарлах учиртай. Энэ хугацаанд олны анхаарлыг сарниулахын тулд 2009 оноос эхлэн амжилт үзүүлсэн бөхчүүдийнхээ “бөгсийг ухах” арга залуу аваргад зааж өгсөн бололтой.

Ертөнцийн гоо бүсгүй Монголд ирнэ



Ирэх сарын эхээр Катриона өөрийн багтайгаа ирж, нэгэн төрийн бус байгууллагын зохион байгуулах үйл ажиллагаанд оролцох юм байна. Харин одоогоор чиглэл болоод хөтөлбөрийг нууцалж байгаа аж. Манайд ирэхийн өмнө Катриона Өмнөд Африкт байрлах LGBTQ нийгэмлэгийн зохион байгуулсан ялгаварлан гадуурхах, хүчирхийлэл, харгислалаас зайлсхийхыг

уриалсан хүний эрхийн төлөөх арга хэмжээнд оролцсон аж. Унаган байгаль, зэрлэг ан амьтад түүнд гүн сэтгэгдэл дэлхийн олон улсаар аялж, сонирхолтой зүйлс үзэх дуртайгаа бичжээ. Катриона Грэйг Филиппиний ард түмэн “хатан” хэмээн өргөмжилж, хайрладаг. Түүний аав нь шотланд гаралтай, ээж нь филиппин эмэгтэй. Тэрээр

Бостон хотын Беркли хөгжмийн коллежийн онлайн сургуулиас хөгжмийн онолын чиглэлээр мастерын зэрэг авсан ба жааз хамтлагт гоцлол дуучин байв. Түүгээр ч зогсохгүй тулааны урлагийн хар бүстэй, анагаах ухааны сувиллахуйн чиглэлээр суралцсан аж. Ахлах сургуулиа төгсөөд Манила руу нүүж, загвар өмсөгчийн зэрэгцээ худалдааны менежерээр ажиллажээ.

Трампын хүү Монголд ан хийхээр ирсэн үү

Өнгөрсөн бямба гарагт АНУ-ын ерөнхийлөгчийн том хүү Доналд Трамп Жуниор Монголд аялахаар ирээд, Алтай таван Богдыг зорьсон. ГХЯ-нд хандаагүй, хувийн шугамаар ирсэн тул албаны ямар ч уулзалт товлоогүй аж. Трампын хөвгүүдийг ангийн хорхойтой, сайн ч бууддаг талаар олон улсын хэвлэлүүд нэг хэсэг шуугисан. Гол шалтгаан нь АНУ-д ховор

ан амьтны арьс, түүхий эд оруулах хоригийг зөөлсөн шийдвэр гаргасан нь зэрлэг Африкт хориотой ан хийх үзэгдлийг ихэсгэсэнтэй холбож шүүмжилж байв. Харин энэ удаад Трамп Жуниор дархан цаазат ангаар баялаг баруун хязгаарыг зорьсон нь дэлхий даяар шуугисан асуудалтай холбож хардахад хүргэлээ. Ховор ан амьтан агнах зөвшөөрлийг орон

нутгаас өгдөг. Тухайн жилд хэдэн төрлийн хичнээн ан хийх хязгаарыг баталсны дараа анчдад үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд үйлчлүүлэгчдээ авдаг байна. Ан тус бүр өөр өөр тарифтай. Тухайлбал, аргаль, угалз зэргийг агнахад 40-50 мянган ам.долларын төлбөртэй. Түүнийг орон нутаг болон анчдыг зуучлах компани хуваан авдаг байна. Ямартай ч АНУ-ын ерөнхийлөгчийн хүү Монгол Улсад “авиралт хийнэ үү, ан хийнэ үү, яана уу” хамаагүй. Орон нутагт хөрөнгө оруулж, алс баруун хязгаарын хөгжилд бага ч гэсэн хувь нэмэр болж байгаа нь чухал биз.



Miss Universe 2018 наадмын ялагч Филиппины гоо бүсгүй Катриона Грей Монгол Улсад айлчлах гэж байна. Тэрбээр ертөнцийн гоо бүсгүйн хүлээх үүргийн дагуу олон улсад хүмүүнлэг, энх тайвны үйлсэд оролцохоор төлөвлөсний нэгд нь Монгол Улс багтжээ.



Гишүүний “нүцгэн лайв” хардлага дагуулав

Засгийн газрын шийдвэрээр уул уурхайн лицензээ цуцлуулсан эзэд, төрийн зарим түшээдтэй Новотел зочид буудалд цугласан тухай мэдээлэл шуугиан тарьж байна. Харин тэр үйл явдалд нэр холбогдсон Д.Хаянхярваа гишүүн гэртээ байгаагаа харуулж “нүцгэн лайв” хийсэн нь интернэт орчинд маргаан дэгдээв. Түүний гэр орноо дүрсэлж, дүү нараа харуулсан тэр бичлэгийг уулзалтын дараа хийсэн гэж хүмүүс хардаж байгаа юм. Үүн дээр нэмээд “Монгол газар”-ын Ц.Мянганбаяр эмнэлэгт хүргэгдсэн шуугианд хариу болгож мань гишүүн “Би тэр Мянганбаяр нарыг чинь танихгүй, мэдэх ч үгүй” гэж жиргэсэн нь социалд хардлагын галыг улам өрдөөд байна. Хаян дарга Ц.Мянганбаяр нартай уулзсан



гэх мэдээллийг хууль хяналтын байгууллагаар шалгуулахаа мэдэгдсэн бол УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ түүнд хандаж “Үнэн худлын хооронд бүх л ертөнц оршдог” хэмээсэн сэтгэгдэл илгээжээ.

Лүндээ дарга уурандаа хүн цохисон гэдэгт итгэх үү



Намын цагаан байранд Ө.Энхтүвшин нарын “эсэргүүнүүд” албан ёсоор жигүүр ургуулах шүүмжлэл ид өрнүүлж, эртний түүхт намын эхний ан цав үүсч байсан үе. Бүлгийн урал дээр Элчин сайд С.Баярыг ОХУ-аас дуудан ирүүлж, намын генсекээр томилохоор хэлэлцэж байжээ. Энэ үед Ц.Нямдорж жигүүр ургуулахыг тас шүүмжлээд, тэр эрчээрээ элдвээр хараан, толь бичигт байхгүй үгээр “шуршиж” гарсан аж. Түүнийг ингэж эрээ цээргүй аашлахыг үл тэвчсэн

намын нөхөр Д.Лүндээжанцан шууд цохиод авчээ. Ид “халж байхдаа” эрүүндээ цохилт авсан Нямка ч уурсан босож, туршлагатай хоёр парламентч барилцаад авсан гэсэн. Хэр баргийн юманд түрүүлж дуугардаггүй, эхэлж хүн цохих нь бүү хэл, эвдрэлцэж байгаа хоёрыг эвлүүлэх шидтэй Лүндээ даргын тэвчээрийг алдартал цамнасан гэхээр Ц.Нямдорж сайдын амнаас тэр үед ямар үг унасан бол доо.

Сайдаасаа сургамж авч сургалтыг чамбайруулна



Монголын боловсролын нэр хүндийг дэлхий нийтэд харуулж орхисон сайдаасаа оновчтой бодлого хүлээсээр суугаа бид ч дүүрсэн улс юм даа. Өнгөрсөн хавар төрийн ордонд болсон ОУПХ-ны чуулганд тэрбээр үг хэлэхдээ өөрийнхөө төдийгүй

улсынхаа боловсролын түвшинг “доош нь хийж” орхисон. Хурлын үндсэн илтгэлүүд англи хэл дээр явах атал боловсролын сайд маань ганцаархнаа төрөлх хэлээрээ дуршигдуулсан нь хурлын төлөөлөгчдийг гайшруулж, төрийн түшээдийг цаашлаад монголчуудаа хулмал-захад хүргэсэн. Хувь хүнийг нь англи хэлгүй гэж “буруутгах” гэсэнгүй. Харин мэдлэгийн хүрээгээ тэлэх, дэлхий нийттэй хөл нийлүүлэн алхахад хамгийн наад захын хэрэгцээ нь гадаад хэл болчихоод байгаа энэ үед боловсролын салбарыг түүнд даатгасан харалган шийдвэрийг л онцлоод байгаа юм. Хөдөө аж ахуйн сайдад зөвлөж явсан түүхч мэргэжилтэй хүн боловсролын сайд болчихоод “туршлагадаа” үндэслэн Монголын сургалтын хөтөлбөрийг шинэчлэхээр чармайж байна. Харин энэ шинэчлэлээрээ алд биений алдаагаа залруулж, Монголын олон хүүхдийг гадаад хэл сурах боломжоор хангахад анхаарна гэж найдъя.